



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@afccp.gov.mn,

Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.01.30 № 01/147

танай _____-ны № _____-т

Тендер түдгэлзүүлэх тухай

“Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэгдсэн эмнэлгээс” Компьютер томографын аппарат ӨВАХХСНЭ/20240102010 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Сетунари” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбогдох ТШЗ 18.1.1, 18.1.2-т, ТТ-2 Шаардлагатай техник үзүүлэлтүүд 2.2 Эх биеийн цооног (gantry bore) 75 см, 2.8 Хамгийн нимгэн зүслэгийн хэмжээ 0,5 мм, 6 Программууд, 6.3 Зураг боловсруулах хурд 50 images/s, бараа нийлүүлэхэд шаардлагатай тусгай шаардлагыг хангахуйц өрсөлдөх бусад аж ахуй эрхлэгчид байгаа эсэх талаар хийсэн судалгаа, тайлбар болон үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг холбогдох бусад материалыг нотлох баримтуудын шаардлага хангуулан 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН